



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/540

Арвайхээр

Хууль бус ан агнуур, тарваган тахал өвчнөөс  
урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15, 23 дугаар зүйлийн 2.5, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны Тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар хориглох тухай А/278 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонууд дээр хөдөө орон нутгаас тарвагны түүхий мах болон бусад эд эрхтнийг хууль бусаар нэвтрүүлэх хандлага ихсэж байгаа тул сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид, байгаль хамгаалагчид, цагдаагийн газрын алба хаагчдыг 2019 оны 08 дугаарын 20-ноос 10 дугаар сарын 10-ны хооронд Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, үзлэг шалгалтыг эрчимжүүлэх, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, мэдээлэл хүргэх ажлыг хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд), Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (Ц.Банди), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Аймаг, сумын худалдааны төвүүдэд болон иргэдийн гар дээрээс хууль бусаар агнасан тарвага, түүхий эд худалдаалж байгаа зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, орон нутгын хяналтын постууд болон хөдөө орон нутагт эргүүл шалгалт хийх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар (О.Ганбат)-т даалгасугай.

3. Хот хоорондын хүн тээврийн ачаа тээшинд тарвагны мах, түүхий эд нууж тээвэрлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох талаар Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Зооноз өвчин судлалын төвтэй хамтран ажиллахыг Авто тээврийн төв (З.Балданням)-д, тарваган тахал өвчнөөс сэргийлэх зөвлөмж, мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг бүх төрлийн хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), Онцгой байдлын газар (Т.Мөнхдорж)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100956